**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Эрдэнэцогт сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БНА-2024/46/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.05 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Б.Нарангэрэл<br>Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**Нэг.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 3

**Хоёр. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 7

**2.1 Төлбөрийн акт** ........ 7

**2.2 Албан шаардлага** ........ 8

**2.3 Зөвлөмж** ........ 10

**Гурав. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 11

**Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл** ........ 13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## Нэг.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

# 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **136,065,261.45** | **164,399,036.27** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 61,977,481.87 | 89,112,720.20 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 61,977,481.87 | 89,112,720.20 |
| **3121** | **Төгрөг** | 61,977,481.87 | 89,112,720.20 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 61,977,481.87 | 89,112,720.20 |
| **33** | **АВЛАГА** | 4,630,450.28 | 1,836,319.57 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 4,590,550.97 | 1,836,319.57 |
| **335** | **Бусад авлага** | 39,899.31 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 39,899.31 | 00.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 4,070,000.00 | 00.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 4,070,000.00 | 00.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 4,070,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 69,457,329.30 | 73,449,996.50 |
| **351** | **Түүхий эд материал** | 619,100.00 | 200,000.00 |
| 35130 | Эм боох материал | 619,100.00 | 200,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 68,838,229.30 | 73,249,996.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,052,000.00 | 165,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 64,911,189.30 | 70,265,136.50 |
| 35460 | Хүнсний материал | 2,275,040.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 600,000.00 | 2,819,136.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,041,331,826.17** | **1,158,444,522.68** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,041,331,826.17 | 1,158,444,522.68 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,033,851,826.17 | 1,150,964,522.68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,111,848,638.90 | 1,254,302,090.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -114,482,551.37 | -137,755,791.57 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 31,156,250.00 | 34,773,380.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -12,658,848.20 | -16,160,143.53 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37,690,600.00 | 37,690,600.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -21,611,263.16 | -23,794,613.12 |
| 39217 | Ном | 1,909,000.00 | 1,909,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,480,000.00 | 7,480,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,480,000.00 | 7,480,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,177,397,087.62** | **1,322,843,558.95** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **540,350.00** | **1,520,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 540,350.00 | 1,520,000.00 |
| **413** | **Өглөг** | 540,350.00 | 1,520,000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 540,350.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 1,520,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 1,520,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,176,856,737.62** | **1,321,323,558.95** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,176,856,737.62 | 1,321,323,558.95 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 100,436,916.11 | 100,436,916.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 100,436,916.11 | 100,436,916.11 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 179,617,063.09 | 324,083,884.42 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 179,617,063.09 | 179,617,063.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 144,466,821.33 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 896,802,758.42 | 896,802,758.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,177,397,087.62** | **1,322,843,558.95** |

## 1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,540,627,670.85** | **637,872,722.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,133,114,770.85** | **149,223,622.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,133,114,770.85 | 149,223,622.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 1,062,087,381.55 | 146,070,582.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 2,686,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **407,512,900.00** | **488,649,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 363,395,900.00 | 454,883,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 363,395,900.00 | 454,883,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 500,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 43,617,000.00 | 33,766,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 43,617,000.00 | 33,766,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **363,172,236.51** | **492,939,060.67** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **363,172,236.51** | **492,939,060.67** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 358,810,404.80 | 492,930,011.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 234,124,558.39 | 315,997,556.25 |
| 210101 | Үндсэн цалин | 179,646,006.26 | 215,282,296.06 |
| 210102 | Нэмэгдэл | 37,957,960.13 | 84,392,554.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 5,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 4,075,936.00 | 10,562,705.38 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 12,444,656.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,415,552.74 | 38,304,749.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,675,042.57 | 25,134,867.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,588,556.73 | 3,316,053.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,958,483.26 | 2,678,201.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 360,243.62 | 648,785.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,833,226.56 | 6,526,841.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,348,243.29 | 32,957,050.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,468,743.29 | 3,588,851.29 |
| 210302 | Түлш, халаалт | 20,988,500.00 | 28,177,199.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 891,000.00 | 1,191,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 305,750.00 | 13,333,438.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 4,943,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200,750.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 105,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 8,390,038.80 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,975,695.00 | 53,356,890.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 419,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,975,695.00 | 52,937,790.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,572,200.00 | 950,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,072,200.00 | 950,000.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,068,405.38 | 37,230,325.77 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,341,850.00 | 5,394,140.28 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,971,000.00 | 2,878,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 20,755,555.38 | 28,957,885.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,361,831.71 | 9,049.05 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,361,831.71 | 9,049.05 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,361,831.71 | 9,049.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,177,455,434.34** | **144,466,821.33** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,177,455,434.34** | **144,466,821.33** |

## 1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **407,512,900.00** | **488,649,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **407,512,900.00** | **488,649,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 363,395,900.00 | 454,883,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 363,395,900.00 | 454,883,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 500,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 43,617,000.00 | 33,766,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 43,617,000.00 | 33,766,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **345,535,418.13** | **461,513,861.67** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **345,535,418.13** | **461,513,861.67** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **341,173,586.42** | **461,504,812.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 238,813,355.39 | 315,997,556.25 |
| 210101 | Үндсэн цалин | 183,488,988.26 | 215,282,296.06 |
| 210102 | Нэмэгдэл | 38,923,180.13 | 84,392,554.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 5,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 3,356,531.00 | 10,562,705.38 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,044,656.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,415,552.74 | 40,141,069.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,981,610.46 | 26,971,186.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,559,600.33 | 3,316,053.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,987,439.66 | 2,678,201.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 491,622.67 | 648,786.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,395,279.62 | 6,526,841.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,923,243.29 | 32,957,050.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,468,743.29 | 3,588,851.29 |
| 210302 | Түлш, халаалт | 20,563,500.00 | 28,177,199.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 891,000.00 | 1,191,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 105,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 105,000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,104,685.00 | 50,662,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,104,685.00 | 50,662,750.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 370,000.00 | 800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 370,000.00 | 800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,442,400.00 | 950,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 942,400.00 | 950,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,999,350.00 | 19,996,386.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,538,550.00 | 17,118,086.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,460,800.00 | 2,878,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,361,831.71** | **9,049.05** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,361,831.71 | 9,049.05 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,361,831.71 | 9,049.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **61,977,481.87** | **27,135,238.33** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 61,977,481.87 | 27,135,238.33 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 61,977,481.87 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 61,977,481.87 | 89,112,720.20 |

## 1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **100,436,916.11** | **896,802,758.42** | **179,617,063.09** | 1,176,856,737.62 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **100,436,916.11** | **896,802,758.42** | **179,617,063.09** | 1,176,856,737.62 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **100,436,916.11** | **896,802,758.42** | **179,617,063.09** | 1,176,856,737.62 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 144,466,821.33 | 144,466,821.33 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **100,436,916.11** | **896,802,758.42** | **324,083,884.42** | 1,321,323,558.95 |

## 1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

## Хоёр. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 143,861.9 мянган төгрөгийн 4 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад тооцоолсон цалин болон гарт олгох цалин 1,309.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, мөн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
2. Тайлант хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг санхүүгийн тайланд 63.7 мянган төгрөгөөр дутуу тусгасан байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, мөн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
3. Цэцэрлэгийн их засварын ажил болох 142,453.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд сайжруулалтаар бүртгээгүй байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
4. Тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангаас 35.0 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, мөн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 217,557.9 мянган төгрөгийн 10 зөрчил[2] илэрснээс 515.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 214,063.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 2,979.2 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 2.1 Төлбөрийн акт

2.1.1 Хүүхдийн хоол хүнсний зардлаас 1,336,000 /нэг сая гурван зуун гучин зургаан мянга/ төгрөгөөр 4 ширхэг хонь худалдан авсан бөгөөд хуулийн дагуу ХХОАТ 133,600 /нэг зуун гучин гурван мянга зургаан зуу/ төгрөгийг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэсэн заалтыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Дээрх хуулийн дагуу суутгаагүй ХХОАТ 133,600 /нэг зуун гучин гурван мянга зургаан зуу/ төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.1.2 Аж ахуйн материал данснаас 286,000 /хоёр зуун наян зургаан мянган/ төгрөгийн материалыг шаардах хуудасгүй, хүүхдийн хоолны зардлаас 95,900 /ерэн таван мянга есөн зуу/ төгрөгийг хоолны менюгүй буюу анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Шийдвэрлэсэн нь*: Дээрх анхан шатны баримтгүй зарцуулсан 381,900 /гурван зуун наян нэгэн мянга есөн зуун/ төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**2.2 Албан шаардлага**

2.2.1 Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад нэг ажилтны 260,300 /хоёр зуун жаран мянга гурван зуу/ төгрөгийн цалинг нийгмийн даатгалд илүү мэдээлсэн байна.

Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө”, 32 дугаар зүйлийн 32.2.2 “Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Нийгмийн даатгалд илүү мэдээлсэн 260,300 /Хоёр зуун жаран мянга гурван зуу/ төгрөгийг суутган тооцож, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2.2.2 Байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/35 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь 73,779,900 /далан есөн сая долоон зуун далан есөн мянга есөн зуу/ төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 3,617,100 /гурван сая зургаан зуун арван долоон мянга нэг зуу/ төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 “Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.4 “Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Цаашид тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдэж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2.2.3 Тус байгууллага нь хичээл практикийн зардлыг төлөвлөх, зарцуулахдаа сургалтын хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн материалд 65 хүртэл хувийг зарцуулах байтал 2,878,300 /Хоёр сая найман зуун далан найман мянга гурван зуу/ төгрөг буюу 100 хувь төлөвлөж, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “ Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 2.6 “Хичээл практикийн зардлыг дор дурдсан зориулалтад заасан хувь хэмжээг баримтлан зарцуулахаар тооцож төлөвлөлт хийнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Цаашид дээрх журмыг зөрчиж зарцуулдаг байдлыг таслан зогсоож,  журамд заасан хувь хэмжээгээр төлөвлөж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2.2.4 Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, заавар аргачлал"-ын 2.2.8-д заасны дагуу  эцэг, эхийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал авалгүйгээр 4,376,000 /дөрвөн сая гурван зуун далан зургаан мянга/ төгрөгийн зөөлөн эдлэл авсан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, заавар аргачлал"-ын 2.1.2 “Сургалтын байгууллага өөрийн удирдлага буюу эцэг эхийн зөвлөлийн оролцоог хангаж, бие даан шийдвэр гаргах”, 2.2.8 “Сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь энэ аргачлалын 2.2.4-д тодорхойлсон санал, шийдвэрийн төслийг өөрийн удирдлага буюу эцэг, эхийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тус зөвлөлийн санал, дүгнэлтээр дэмжигдсэн жагсаалтыг баталснаар худалдан авах ажиллагааг явуулах” гэсэн заалтыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Цаашид журмыг зөрчиж эцэг эхийн зөвлөлийн саналыг авалгүй худалдан авалт хийдэг байдлыг таслан зогсоож, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2.2.5 Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 1,998,000 /нэг сая есөн зуун ерэн найман мянга/ төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн, мөн 23,213,800 /хорин гурван сая хоёр зуун арван гурван мянга найман зуу/ төгрөгийн и баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн  байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6.”Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5. Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”гэсэн заалтыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Худалдан авалтын  1,998,000 /нэг сая есөн зуун ерэн найман мянга/ төгрөгийн и баримтыг 2024.03.20-ны дотор нөхөн шивүүлэх, илүү шивсэн 23,213,800 /хорин гурван сая хоёр зуун арван гурван мянга найман зуу/ төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2.2.6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.5-д заасан 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 29,668,100 /хорин есөн сая зургаан зуун жаран найман мянга нэг зуу/ төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй, хуулийн 6.4.8-д заасан төсөв өмч, хөрөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой дулаан, хүүхдийн хоол хүнс нийлүүлэх 74,269,700 /далан дөрвөн сая хоёр зуун жаран есөн мянга долоон зуу/ төгрөгийн 2 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 ." цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасан 103,937,800 /нэг зуун гурван сая есөн зуун гучин долоон мянга найман зуу/ төгрөгийн мэдээллийг бүрэн байршуулан, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

**2.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад байгууллагын эрхлэгчийн бүтэц орон тоо баталсан тушаалаар бичиг хэргийн ажилтны орон тоог батлаагүй байхад тус байгууллагын ажилтанд бичиг хэргийн ажлыг 2023.09.01-ны өдрөөс хавсруулан албан тушаалын 40 хувь буюу нийт 1459.2 мянган төгрөгийн цалинг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, цаашид батлагдсан орон тоондоо нийцүүлэн ажилчдын цалин хөлсийг тогтоож байх зөвлөмжийг хүргүүлэв.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант хугацааны эцэст 1,520.0 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 “Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Цаашид Төсвийн тухай хуульд заасны дагуу өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Гурав. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад тооцоолсон цалин болон гарт олгох цалин 1309.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1 | 1,309.8 | 1 | 1,309.8 | | | 1 | 1,309.8 | | |
| Тайлант хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг санхүүгийн тайланд 63678 төгрөгөөр дутуу тусгасан байна. | 1 | 63.7 | 1 | 63.7 | | | 1 | 63.7 | | |
| Цэцэрлэгийн их засварын ажил болох 142,453.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд сайжруулалтаар бүртгээгүй байна. | 1 | 142,453.5 | | | 1 | 142,453.5 | 1 | 142,453.5 | | |
| Тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангаас 35.0 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. | 1 | 35.0 | | | 1 | 35.0 | 1 | 35.0 | | |
| Дүн | **4** | **143,861.9** | **2** | **1,373.5** | **2** | **142,488.4** | **4** | **143,861.9** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад байгууллагын эрхлэгчийн бүтэц орон тоо баталсан тушаалаар бичиг хэргийн ажилтны орон тоог батлаагүй байхад тус байгууллагын ажилтанд бичиг хэргийн ажлыг 2023.09.01-ны өдрөөс хавсруулан албан тушаалын 40 хувь буюу нийт 1459.2 мянган төгрөгийн цалинг олгосон байна. | 1 | 1,459.2 | | | | | 1 | 1,459.2 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант хугацааны эцэст 1520.0 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалттай нийцэхгүй байна. | 1 | 1,520.0 | | | | | 1 | 1,520.0 |
| Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад нэг ажилтны 260.3 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалд илүү мэдээлсэн байна. | 1 | 260.3 | | | 1 | 260.3 | | |
| Байгууллагын даргын 2023.12.27-ны өдрийн А/35 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь 73,779.9 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 3617.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй байна. | 1 | 77,397.0 | | | 1 | 77,397.0 | | |
| Тус байгууллага нь хичээл практикийн зардлыг төлөвлөх, зарцуулахдаа сургалтын хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн материалд 65 хүртэл хувийг зарцуулах байтал 2,878.3 мянган төгрөг буюу 100 хувь төлөвлөж, зарцуулсан байна. | 1 | 2,878.3 | | | 1 | 2,878.3 | | |
| Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, заавар аргачлал"-ын 2.2.8-д заасны дагуу эцэг, эхийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал авалгүйгээр 4376.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэл авсан байна. | 1 | 4,376.0 | | | 1 | 4,376.0 | | |
| Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 1,998.0 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн, мөн 23,215.8 мянган төгрөгийн и баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байна. | 1 | 25,213.8 | | | 1 | 25,213.8 | | |
| Хүүхдийн хоол хүнсний зардлаас 7 дугаар сард иргэн Дорждэрэмээс 1336.0 мянган төгрөгөөр 4 ширхэг хонь худалдан авсан, түүнтэй холбоотой ХХОАТ болох 133600 төгрөгийг суутгаагүй, мөн тендерийн бус худалдан авалт хийсэн байна. | 1 | 133.6 | 1 | 133.6 | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Аж ахуйн материал данснаас 3 дугаар сард зарцуулсан 286,0 төгрөгийн материалыг шаардах хуудасгүй, 1 ба 7 дугаар саруудад 95.9 мянган төгрөгийн хүүхдийн хоолны менюгүй буюу анхан шатны баримтгүй зарцуулсан байна. | 1 | 381.9 | 1 | 381.9 | | | | |
| **Нийт дүн** | **9** | **113,620.1** | **2** | **515.5** | **5** | **110,125.4** | **2** | **2,979.2** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.5-д заасан 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 29668.1 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй, хуулийн 6.4.8-д заасан төсөв өмч, хөрөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой дулаан, хүүхдийн хоол хүнс нийлүүлэх 74269.7 мянган төгрөгийн 2 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна. | 1 | 103,937.8 | | | 1 | 103,937.8 | | |
| Дүн | **1** | **103,937.8** | | | **1** | **103,937.8** | | |

## Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | | | 1 | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | | | **1** | | | | | |

------------оОо-------------